

*Иргэний Нисэхийн Ерөнхий газар*



**Үзүүлэлтэд тулгуурласан навигацыйн хэрэгжилт, зохицуулалтын ажлын баг (PBNICG-1)**

Улаанбаатар, Монгол Улс, 2019 оны 6 дугаар сарын 21

## **Хэлэлцэх асуудал 6: Үзүүлэлтэд тулгуурласан навигацыйн хэрэгжилт, зохицуулалт**

### **МОНГОЛ УЛС**

(Үзүүлэлтэд тулгуурласан навигацыйн хэрэгжилт, зохицуулалтын ажлын баг)

#### **ХУРААНГУЙ**

Энэхүү IP-аар Олон Улсын Иргэний нисэхийн байгууллагын төлөөллүүдийг оролцуулсан Үзүүлэлтэд тулгуурласан навигацыйн хэрэгжилт, зохицуулалтын ажлын хэсгийн 6 дахь удаагийн (PBNICG-6) хурлын шийдвэрийг танилцуулна.

#### **1. ТАНИЛЦУУЛГА**

- 1.1. Үзүүлэлтэд тулгуурласан навигацыйн хэрэгжилт, зохицуулалт (PBNICG)-ын 6 дахь удаагийн хурал Индонези Улсын Балид 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 27-ний өдрүүдэд зохион байгуулагдсан бөгөөд хуралд 22 улс (Австрали, Бангладеш, Камбодж, БНХАУ, Фижи, Энэтхэг, Лаос, Малайз, Малдив, Монгол, Мянмар, Шинэ Калиндони, Шинэ Зееланд, Пакистан, Филиппинн, Солонгос, Сингапур, Тайланд, Тимор, Тонга, Виетнам), 2 олон улсын байгууллага (IATA, ICAO), 70 оролцогч (Иргэний нисэхийн удирдлагын түвшний албан тушаалтан, байцаагч, агаарын навигацыйн бодлогын түвшний албан хаагч, журам зохиогч дизайнер, инженер, агаарын тээвэрлэгчийн төлөөллүүд)-ийг хамарсан томоохон хэмжээний хурал зохион байгуулагдсан.
- 1.2. Энэхүү хурлаар нийт 22 улс Үзүүлэлтэд тулгуурласан навигацыйн хэрэгжилт, зохицуулалт, цаашид авч хэрэгжүүлэхээр ажиллаж буй төсөл, үүссэн хүндрэл, харилцан мэдээлэл солилцоо, хэлэлцүүлэг зэрэг 11WP, 18 IP, 6 танилцуулга пресентаци танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулагдаж харилцан туршлага солилцсон, мэдээлэл авсан, цаашдын хэтийн төлөвлөлтөд чухал нөлөөтэй хурал болсон. Үүнд:

- **Аюулгүй ажиллагааны үнэлгээний дадлага:**

- Энэхүү дадлагаар PBNICG ажлын хэсгээс боловсруулан гаргасан аюулгүй ажиллагааны үнэлгээ хийх шалгах хуудасаар Мянмар Улсын зарим нисэх буудлуудын нислэгийн журам зохиолтод 20 улсын 52 оролцогчийг мэргэжлээс шалтгаалж 6 багт хуваан үнэлгээ хийж цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай зарим алдаа дутагдал, үл

нийцлийг илрүүлэн бусад оролцогч нарт танилцуулж харилцан туршлага солилцсон, зохиогдсон аргачлалыг өөрийн улс оронд хэрхэн ашиглах чухал ач холбогдолтой дадлага болсон.

- Түүнчлэн энэхүү аюулгүй ажиллагааны үнэлгээ хийх шалгах хуудас нь зөвхөн RNP APCH нислэгийн журмуудад бус SID, STAR болон En-route-д хэрэгжүүлэх шалгах хуудсууд тус тус боловсруулагдсан.

- **ОУ-ын баримт бичгийн өөрчлөлт шинэчлэлт, төлөвлөлт:**

- DOC8168 PANS OPS Vol I 6 дахь өөрчлөлт 2018.

- Шинэ бүтэц;
- Шинэ PBN агуулга;
- PBN-ний шаардлагууд.

- Дос 9613 PBN журам 5 дахь хувилбар 2020 оны эхний хагас хүртэл хойшилсон.

- RNP AR OPS;

- Шинэ нисэн гарах тодорхойлолтууд;
- AR APCH болон AR DP тусдаа шаардлага.

- RNP өөрчлөлт;

- PBN to xLS;
- RNP 0.3;
- 2 дугаар тойрог

- PBN operational approval: Хэрхэн чиглүүлэх.

- WP02 /GANP өөрчлөлт ICAO Бээжин дэх бүсийн төв танилцуулсан/;

- ICAO-ийн Бээжин дэх бүсийн төвөөс Дэлхийн агаарын навигацийн төлөвлөгөө (GANP)-д зарим нэг өөрчлөлтүүд орж байгаа талаар товч танилцуулсан. Үүнд:

- Basic building blocks (BBB) нэмэгдсэн;
- Aviation system block upgrades (ASBU)-ийн зарим модулиуд нэгтгэгдсэн.

- Дээрх өөрчлөлтүүдийг 2019 оны 9 дүгээр сард ICAO-ийн 40 дэх ассемблигаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

- Circular 353 дагуу улс орнууд PBN RNAV-аас RNP ойртолтын нислэгийн журмын зургийг шинэчлэх ажлыг улс орнууд 2019 оны 6 дугаар сарын

дотор хийхийг зөвлөсөн бөгөөд энэхүү ажил CNS/SG23 дугаар хурлаар баталгаажина.

- Түүнчлэн **DOC4444-т ADS-B phraseology**-ийн талаар тусгах санал оруулах асуудал хэлэлцэгдсэн. Жнь:
  - “RE-ENTER ADS-B AIRCRAFT IDENTIFICATION”
  - “TRANSMIT ADS-B IDENT”
  - “STOP SQUAWK TRANSMIT ADS-B ONLY” or “STOP ADS-B TRANSMISSION, SQUAWK (CODE) ONLY”
  - “TRANSMIT ADS-B ALTITUDE”
  - “STOP ADS-B ALTITUDE TRANSMISSION [(WRONG INDICATION, or reason)]”
- Мөн энэ хурлын шийдвэрээр шалгалтын нислэг зохион байгуулах болон нислэгээр шалган баталгаажуулах ***catalogue*** баталгаажсан. <https://www.icao.int/APAC/Pages/new-eDocs.aspx>.
- Real time ***GNSS status monitoring***-ийг газарт хийх шаардлагатай. Тухайлбал улс орнууд дараах үйл ажиллагааг нэвтрүүлэхийг яаравчлах. Үүнд:
  - Радио навигацийн үйлчилгээнд GNSS-д суурилсан үйл ажиллагааг тодорхойлох;
  - Нислэгийн удирдагч GNSS status monitoring хийх;
  - Хэрэглэгч GNSS/RAIM идэвхгүй, алдаатай эсэхийг мэдэх зорилгоор ашиглах;
  - Нисгэгч GNSS статусийг НУ-д мэдэгдэх;
  - Тусгалыг AIC болон AIP-аар зарлах.
- GNSS ашиглан хэвтээ зайчлалыг багасгах гарын авлага ICAO circular 321, 343-ийг судлах;
- 2018 оны байдлаар 10 улс, Eurocontrol, үйлдвэрлэгч байгууллага, Airbus, Boeing GBAS-ийг өөр өөр түвшинд хэрэгжүүлж байна. SBAS-ийг хэрэгжүүлэх нь үндэсний дэд бүтэцтэй холбоотой ажил болох талаар мэдээлэл өгсөн.

— ТӨГСӨВ —